

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДЛЫН ДУНДАЖ НОРМАТИВ, САНХҮҮЖҮҮЛЭХ АРГАЧЛАЛ, НЭМЭГДЭЛ УРАМШУУЛАЛ ОЛГОХ ЖУРАМ

Журмын төслийн танилцуулга

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5 дахь заалтын дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын “Аргачлал, зардлын норматив батлах тухай” хамтарсан тушаал 2022 оны 01 дүгээр сард батлагдан хэрэгжиж байна.

Сангийн яам болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас хөтөлбөр тус бүрээр “Үр дүнд суурилсан төлөвлөлт, төсөвлөлт”-ийг НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр болон Хүүхдийн сантай хамтран Хүүхэд хөгжил, хамгаалал хөтөлбөрийг үр дүнтэй төлөвлөх, төсөвлөх шаардлагатай байгаа тул “Монгол улсад ТХЗ-той уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн хүрээнд үйл ажиллагааг хэрэгжүүлж эхлээд байна.

Монгол улсад “Хүүхдийн эсрэг хүчирхийлэл буурсан байна” гэсэн гол зорилгыг тулгуур болгон үйлчилгээ шаардлагатай хүүхэд бүрт хүүхэд хамгааллын үйлчилгээ хүрдэг байх, үр дүнтэй байх, үр ашигтай байх зарчмыг баримтлан тухайн аргачлалыг өөрчлөх шаардлага тулгарч байна. Одоо хэрэгжиж буй аргачлалын хүрээнд үйл ажиллагааны болон санхүүжилтийн хүрээнд судалгаа явуулахад дараах үндсэн асуудлыг журмаар шийдвэрлэх шаардлагатай байна. Үүнд:

- Хүүхэд хамгааллын үйлчилгээ авсан, кэйс нээсэн тухай тоо мэдээ зөрүүтэй,
- Хүүхэд хамгааллын үйлчилгээний санхүүжилтийг тохиолдол /кэйс/, бүрээр тооцдоггүй,
- Батлагдсан норматив хүрэлцдэггүй,
- Хамтарсан багийн гишүүдэд урамшуулал олгодоггүй,
- Хүүхэд хамгааллын үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдийн хөгжлийн санхүүжилт төлөвлөгдөөгүй,
- Хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх үйлчилгээний зардлыг нэмэгдүүлэх,
- Үйлчилгээ болон санхүүжилтийн хэрэгжилтэд тавих хяналт сул зэрэг болно.

Журмын төслөөр дараах асуудлыг шийдвэрлэсэн болно. Үүнд:

- Кейс бүрийн онцлогтой уялдуулан холбогдох зардал өөр өөр байх тул тухайн онцлогоос шалтгаалан хамтарсан баг батлагдсан зардлын дундаж нормативаас сонголт хийх байдлаар шаардлагатай санхүүгийн хүсэлтийг гаргаж байх,
- Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх орчин бүрээр үйлчилгээ үзүүлэх чиг үүргийг хүлээсэн Төсвийн Ерөнхийлөн захирагч нь шаардлагатай төсвийг багцдаа тусгаж батлуулдаг байх заалт тусгасан,
- Шаардлагатай санхүүжилтийг шуурхай тусламжийн үйлчилгээний хүрээнд сар бүр, хүүхэд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний хүрээнд ажлын 5 хоногт багтаан олгодог байх,
- Хүүхэд хамгааллын хуулийн 12.6 дахь заалтын дагуу Хамтарсан багийн гишүүдэд нэмэгдэл урамшуулал олгох зохицуулалтыг тусгасан,
- Зардлын зарим дундаж нормативд тарифын өөрчлөлт оруулсан,

- Хүүхэд хамгааллын үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдийн хөгжлийн санхүүжилтийг Хүүхэд хамгаалах, нөхөн сэргээх болон урьдчилан сэргийлэх үйлчилгээний хүрээнд санхүүжүүлж байхаар норматив баталсан,
- Урьдчилан сэргийлэх үйлчилгээний зардлыг нэмэгдүүлсэн бөгөөд Мэргэжлийн удирдлагаар хангах тогтолцоо, Мэргэшлийн удирдагч нарыг бэлтгэх, сургах, чадварыг бэхжүүлэх эх үүсвэрийг төсөвт тусгах,
- Үйл ажиллагааны хувьд болон санхүүгийн гүйцэтгэлийг хэрхэн хянаж байх талаар шинэ бүлэг оруулсан зэрэг болно.

Үүнээс гадна Хүүхэд хамгааллын үйлчилгээний санхүүжилт нь цахим мэдээллийн сан дахь тохиолдол (цаашид “Кейс” гэх)-ын тоо, үзүүлсэн үйлчилгээний үр дүнд үндэслэн олгогдох үндсэн зарчмыг баримтлах тул салбарын хүрээнд хүүхэд хамгааллын үйлчилгээний Үндэсний платформыг бий болгох зайлшгүй шаардлагатай байна. Одоогийн байдлаар Шуурхай-108, Хүүхдийн эрсдэлийн программ-ABLE, Нийгмийн ажилтны мэдээллийн систем-НАМС, түр хамгаалах байраар үйлчилгээ авсан хүүхэд Е-тусламж гэсэн тусдаа 4 дата баазтай бөгөөд баазууд нь хоорондоо уялдаа холбоогүй, мэдээллийн бодит байдал хангагдаагүй, мэдээлэл дамжуулах цаг хугацаа удаашралтай байна.

Мөн журмын төсөлд нэмэлт тайлбар шаардлагатай заалтуудын дор “Тайлбар:-” байдлаар дэлгэрүүлж тодруулга хийсэн болно.

Журмын төсөл боловсруулахад оролцогч талуудын оролцоог хангах зорилгоор Сангийн яамны төлөөлөл, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын “Ажлын хэсэг байгуулах тухай” 2023 оны А/94 тушаалаар батлагдсан ажлын хэсэг, орон нутаг дахь Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын төлөөлөл, асуудал хариуцсан Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн төлөөлөлд танилцуулж саналыг тусгасан.

Хамтарсан тушаалыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөхөөр тушаалын төсөлд тусгасан тул 2023 оны батлагдсан төсөвт нөлөөлөхгүй болно. Хүүхэд хамгааллын нийт зардлыг 14.3 тэрбум төгрөгөөр 2024 оны төсвийн төсөлд тусгасан. Энэ нь 2023 оны төсвөөс 6.3 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байна.

---oOo---